



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/487

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Шинэ суурьшлын бүсэд цахилгааны эх үүсвэр татах (Хишиг-Өндөр сум)” ажлыг гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөн булаг” ХХК-тай 145,353,457 (нэг зуун дөчин таван сая гурван зуун тавин гурван мянга дөрвөн зуун тавин долоон) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д даалгасугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөн булаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Хишиг-Өндөр сумын Засаг дарга (О.Буянбадрах)-д даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 07-ны/ний өдрийн
А.Н.О. дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Нормчлолын сан	227,154	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	2,523,936	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	1,261,968	Ү.Бямбасүрэн
4	Магадалшгүй ажил	2,523,936	Ү.Бямбасүрэн
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 70 хоног	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Б.Ариунболд